



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/801

Булган сум

**“Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн
зөвлөгөөн зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан “Улсын хил хамгаалалтад иргэнийг оролцуулах журам”-ын 3.1, 3.3, 3.8 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэх зөвлөгөөнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах 940,000 (есөн зуун дөчин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д. ПҮРЭВ-ОЧИР



6324011190